



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/52

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 38 дугаар зүйлийн 38.1, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Түчилравдан овогтой Сүхболд (РУ86011711)-ын хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/28 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь заалтаар Мөрөн сум 8 дугаар баг 13 дугаар байр 26 тоотод байршилтай 40м<sup>2</sup> худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн 6712016479 нэгж талбарын дугаартай газрыг иргэн Батболд овогтой Батсүх (РУ89052835)-д 23 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/28 дугаар захирамжийн хавсралтын 6 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Батболд овогтой Батсүх (РУ89052835)-той газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6712010256